

**АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛ, САР, ДОЛОО ХОНОГИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ, ТАЙЛАНГ
ИРҮҮЛЭХ, ХҮЛЭЭН АВЧ ДҮГНЭХ ГЭРЭЭ**

20..... оны сарын өдөр

№

Улаанбаатар

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, 48 дугаар зүйлийн 48.6.2-48.6.3 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-10.1.5 дахь хэсэг, Уул уурхайн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас мэдээ, тайлан ирүүлэх хуваарь”, Ашигт малтмалын газрын даргын 2014 оны а-80 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”, “Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журам”-д тус тус заасныг үндэслэн

Нэг талаас Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг төлөөлж захирал/хаяг: улсын бүртгэлийн дугаар:, регистрын дугаар:, аймаг, нийслэл, утас/факс:, гар утас:/,

Нөгөө талаас Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болох АМГ-ын Нүүрсний хэлтсийн дарга Б.Алтсүх /хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл

1.1 Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж тал нь 20.... оны үйл ажиллагааны төлөвлөгөөний жил, сар, долоо хоногийн биелэлтийн мэдээ, тайланг “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”-т заасан хугацааны дотор үнэн зөв гарган Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болох АМГ-ын Нүүрсний хэлтэст ирүүлнэ.

1.2 Жилийн тайланд АМГ-ын даргын а-80 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”-т заасан мэдээ, сарын тайланд батлагдсан маягтын “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас мэдээ, тайлан ирүүлэх хуваарь”-д заасан мэдээ, долоо хоногийн тайланд бүтээгдэхүүн гаргалт, борлуулалт, экспортолсон бүтээгдэхүүн, төлөвлөгөө биелээгүй бол түүний шалтгаан, тайлбар бүхий мэдээг тухайн долоон хоног, сар болон жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж тусгана.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Талууд гэрээг 20... оны ... дугаар (дүгээр) сарын өдрөөс эхлэн 20 ... оны ... дүгээр сарын өдөр хүртэл гурван жилийн хугацаатай байгуулна.

Гурав. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

3.1 Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх явцад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүрэн гүйцэтгэх боломжгүй болсон бол сар, долоо хоногийн мэдээг ирүүлэхдээ энэ талаар тайлбар бичиж, шаардлагатай баримт, материалын хамт Нүүрсний хэлтэст бичгээр хүргүүлнэ.

3.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажилд өөрчлөлт оруулах бол энэ тухайгаа долоо хоног, сарын мэдээ гаргахаасаа өмнө урьдчилан мэдэгдэж, шаардлагатай өөрчлөлтийг оруулж зөвшөөрөгдсөн төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийж хүргүүлнэ.

3.3 Энэхүү гэрээний 3.2-д заасан өөрчлөлтийг баталгаажуулсан бол тухайн өөрчлөлт орсон байдлаар сар, долоо хоногийн мэдээ гаргана.

3.4 Сарын мэдээг сар бүрийн 5-ны дотор, долоо хоногийн мэдээг долоо хоногийн Баасан гаригт албан тушаалтай овогтой -ын цахим хаягаас хүргүүлэх эсвэл дугаарын утаснаас мэдэгдэнэ.

3.5 Мэдээ өгөх албан тушаалтан болон түүний цахим хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор АМГ-ын Нүүрсний хэлтэст мэдэгдэнэ.

Дөрөв. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болох АМГ-ын Нүүрсний хэлтсийн эрх, үүрэг

4.1 Ирүүлсэн мэдээ, тайланг хүлээн авч, тайланд тусгасан мэдээлэл, холбогдох материалыг шалгаж, дүгнэлт гаргана.

4.2 Ирүүлсэн мэдээ, тайланг буруу, алдаатай гаргасан бол энэ талаар үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид мэдэгдэж, хариу тайлбар, шаардлагатай баримт, материалыг ирүүлэхийг мэдэгдэнэ.

4.3 Мэдээ, тайланг хүлээн авсны дараа нэгтгэн боловсруулалт хийж, дүгнэлт гаргана. Сарын мэдээг дараа сар бүрийн 8-нд багтаан, жилийн мэдээг Ашигт малтмалын тухай хуульд заасан хугацаанд Уул уурхайн яам, холбогдох нэгжид хүргүүлнэ.

4.4 Мэдээ, тайланг Нүүрсний хангамж, статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Даваа овогтой Эрдэнэчимэгийн Erdenechimeg@mram.gov.mn цахим хаягаар эсвэл 263917 дугаарын утсаар хүлээн авна.

Тав. Хүлээх хариуцлага

5.1 Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэхүү гэрээнд заасан үүргээ огт биелүүлээгүй, мэдээ, тайланг ирүүлээгүй шалтгаанаа тайлбар, холбогдох материалын хамт удаа дараа ирүүлээгүй бол энэ талаарх зөрчлийг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж баримтжуулан Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх саналыг Мэргэжлийн хяналтын байгууллагад эсхүл Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-10.1.5 дахь хэсэгт заасны дагуу тухайн тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг Кадастрын асуудал хариуцсан нэгжид гаргана.

Гэрээ байгуулсан:

Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж талыг төлөөлж: “.....” ХХК-ийн
... албан тушаалтай
.. овогтой

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болох АМГ-ын Нүүрсний хэлтсийн дарга Баатар овогтой Алтсүх

/гарын үсэг/

/гарын үсэг/